



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Шинжээчийн зөвлөл байгуулах тухай


Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2017 оны А/295 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм”-ийн 3.7 дах хэсгийн заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Үндэсний төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн эрхлэх асуудалд мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй “Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх” шинжээчийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шинжээчийн зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


Хоёр. Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт дүн шинжилгээ хийх шинжээчийн зөвлөлийг холбогдох журамд заасны дагуу ажиллуулах, шийдвэр, дүгнэлт гарган танилцуулахыг Зөвлөлийн дарга /З.Оюунбилэг/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Г.ЭНХБАТ



Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2019 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн
А/41 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



“АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛД ХЯНАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭ ХИЙХ” ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

З.Оюунбилэг Сэргээн засварлалтын зөвлөх архитектор, Ph.D


Гишүүд:

Г.Анхсанаа	Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга
М.Оюунтулга	Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газар, Ерөнхий технологич
Б.Адьяа	Архитектор
Д.Батаа	Гавьяат барилгачин, зөвлөх архитектор
Ж.Баясгалан	Барилгын инженер
Д.Чинбадам	Архитектор, магистр
Б.Бизьяасүрэн	ШУТИС-ийн Барилга, архитектурын сургууль Архитектурын салбарын багш, магистр

Нарийн бичгийн дарга:

Ц.Цолмон Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг авран хамгаалах газар, Дэлхийн өвийн дурсгал хариуцсан мэргэжилтэн

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2019 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн
А/41 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛД ХЯНАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх шинжээчийн зөвлөл" (цаашид "Зөвлөл" гэнэ) нь дурсгалт уран барилга болон түүхэн барилга, эртний хот суурины үлдэгдэл, туурь зэрэг архитектурын дурсгалыг хадгалж хамгаалах(conservation), сэргээн засварлах(restoration) ажилд үзлэг хяналт хийх, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх зэрэг ажлыг гүйцэтгэхэд энэхүү журмыг мөрдөж ажиллана.

1.2. "Архитектурын дурсгал" (Architectural heritage) гэж эртний хот суурин, хэрэм цайзын үлдэгдэл, балгас, туурь, уран барилгын цогцолбор, сум дуган, хийд, гудамж талбай, байшин барилга зэргийг хэлнэ. "Дурсгалт барилга"(Historic building) гэж биднийг гайхшируулах мэдрэмжийг төрүүлж, түүнийг бүтээсэн хүмүүс болон соёлын талаар илүү ихийг мэдэх боломжийг олгодог, архитектур, гоо зүй, түүх, баримтат, археологи, нийгэм, эдийн засгийн тэр ч байтугай улс төрийн болон бэлгэдлийн үнэ цэнийг агуулсан барилгыг хэлнэ.

1.3. Шинжээчийн зөвлөл нь архитектурын дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажилд хяналт үзлэг болон дүн шинжилгээ хийхдээ "Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах Олон улсын дүрэм"(Венецийн Харт), "Архитектурын дурсгалыг сэргээн засварлах, хадгалж хамгаалах, дүн шинжилгээ хийх Олон улсын зарчим", "Соёлын өвийг хамгаалах тухай хууль", "Барилгын тухай хууль", "Архивын тухай хууль", "Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам" болон бусад холбогдох дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.4. Зөвлөл нь Соёлын өвийн Үндэсний төвийн дэргэд ажиллана.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн

2.1. Зөвлөл нь орон тооны бус бөгөөд Зөвлөлийн дарга, 7 гишүүн, нарийн бичгийн дарга бүгд 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.

2.2. Зөвлөлийн дарга, гишүүд нь архитектурын дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр мэргэшсэн болон зөвлөх архитектор ба инженер, уран зураач, судлаач, ландшафтын архитектор мэргэжлийн магистр, доктор зэрэгтэй байна.

2.3. Зөвлөлийн дарга, гишүүдэд ажиллах хугацаанд үнэмлэх олгоно.

Гурав. Зөвлөлийн эрх, үүрэг

- 3.1. Зөвлөл нь дараах эрхтэй байна. Үүнд:
 - 3.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр явагдаж буй архитектурын дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажилд үзлэг хийх;
 - 3.1.2. Дурсгалт барилгыг сэргээн засварлах ажлын тендер зохих хууль, журам, дүрмийн дагуу явагдаж буйд хяналт тавих;
 - 3.1.3. Дурсгалт барилгыг сэргээн засварлах ажлын зургийг үзэх, зөвлөх, бурууг засуулах;
 - 3.1.4. Архитектурын дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах ажилд зөвлөгөө өгөх;
 - 3.1.5. Архитектурын дурсгалын нөхцөл байдал, эвдрэл гэмтлийн талаар дүн шинжилгээ хийх;
 - 3.1.6. Архитектурын дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах талаар санал боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэх;
 - 3.1.7. Архитектурын дурсгалын уламжлалт орчин, хамгаалалтын бүс буюу хүрээлэн буй орчны хадгалалт хамгаалалтын талаар зөвлөх.
- 3.2. Зөвлөл дараах үүрэгтэй. Үүнд:
 - 3.2.1. Зөвлөлийн гишүүд хуралд биечлэн ирж идэвх санаачилгатай оролцох;
 - 3.2.2. Архитектурын дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажлын холбогдох хууль, журам, дүрэм зарчмыг мөрдөж ажиллах;
 - 3.2.3. Дурсгалт барилгын сэргээн засварлах ажлыг газар дээр үзэх, дүн шинжилгээ хийх;
 - 3.2.4. Дараах архитектурын дурсгалд үзлэг, дүн шинжилгээ хийх. Үүнд:
 - а/ Эрсдэлд орсон, яаралтай хамгаалах шаардлагатай архитектурын дурсгал;
 - б/ Дэлхийн өвд бүртгэгдсэн дурсгалт газарт орших архитектурын дурсгал;
 - в/ Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад орсон архитектурын дурсгал;
 - г/ Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байгаа архитектурын дурсгал.
 - 3.2.5. Зөвлөлийн хурлаас гарсан шинжээчийн дүгнэлт, зөвлөмжид гарын үсэг зурж баталгаажуулах;
 - 3.2.6. Зөвлөлийн шийдвэрийг холбогдох дээд байгууллага, мэргэжлийн байгууллагууд болон олон нийтэд танилцуулах;
 - 3.2.7. Дурсгалт барилгыг сэргээн засварлах ажлын гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, зөвлөгөө өгөх;
 - 3.2.8. Архитектурын дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах талаар гарын авлага, аргачлал, зөвлөмж боловсруулах, сурталчлах, хурал зөвлөгөөнд оролцох;

Дөрөв. Зөвлөлийн ажиллах журам

- 4.1. Зөвлөлийн хурлыг шаардлага гарсан тухай бүрд зарлан хуралдуулна.
- 4.2. Зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга удирдана. Зөвлөлийн дарга нь зөвлөлийн ажлыг бүхэлд нь хариуцаж, удирдан зохион байгуулах ба нарийн бичгийн даргад чиглэл өгнө.
- 4.3. Зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар гаргасан дүгнэлт, зөвлөмжид зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр шийдвэр болно.
- 4.4. Зөвлөлийн дарга нь гишүүдийн зөвлөлийн үйл ажиллагаанд оролцсон байдлыг бодитой дүгнэн ажлын хөлс олгуулах саналыг тавина.

Тав. Зөвлөлийн үйл ажиллагааны зардал

5.1. Зөвлөлийн гишүүдэд мөнгөн урамшуулал олгох асуудлыг Соёлын өвийн үндэсний төвийн захирлын тушаалаар баталсан “Соёлын өвийн үндэсний төвийн дэргэдэх Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл, Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл, Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх шинжээчийн зөвлөлийн гишүүнд урамшуулал олгох журам”-ын дагуу шийдвэрлэнэ

5.2. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Соёлын өвийн үндэсний төвийн жил бүрийн төсөвт тусгуулж санхүүжүүлнэ.